



СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ЭТГЭЭДТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Зорилго

- 1.1. Энэхүү журмын зорилго нь "Монголиан Файнэншл Партнерс" ББСБ ХХК /цаашид, "компани" гэх/-ийн сонирхлын зөрчлийг зохицуулах, хувьцаа эзэмшигчидийн нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох, гэрээ хэлцэл байгуулах, тэдгээрийг хянахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

- 2.1 Энэхүү журмыг компанийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) болон бусад хамаарал бүхий этгээд нар дагаж мөрдөнө.

Гурав. Нэр томъёоны тайлбар

- 3.1 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 3.1.1 "Сонирхлын зөрчил" гэж хувь хүний хувийн сонирхол /заавал мөнгөн хэлбэртэй байх албагүй/, албаны үүрэг хоёр хоорондоо харшилж байгаа нөхцөл байдлыг;
 - 3.1.2 "Сонирхлын зөрчил бүхий этгээд" гэж Компанийн тухай хуулийн 89.1-д заасныг;
 - 3.1.3 "Нэгдмэл сонирхол бүхий этгээд" гэж Компанийн тухай хуулийн 89.2-д заасныг;
 - 3.1.4 "Дотоод мэдээлэл эзэмшигч" гэж хувьцаа эзэмшигчид, ТУЗ, Гүйцэтгэх захирал болон тэдгээртэй холбоотой этгээдүүдийг;
 - 3.1.5 "Эрх бүхий албан тушаалтан" гэж Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасны дагуу тодорхойлсон албан тушаалтныг;
 - 3.1.6 "Сонирхлын зөрчилтэй хэлцэл" гэж сонирхлын зөрчил бүхий этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцаа эзэмшиж байгаа групптэй хийж байгаа хэлцлийг;
 - 3.1.7 "Сонирхлын зөрчилтэй субъект" гэж хувьцаа эзэмшигч, нэгдмэл сонирхол бүхий этгээд, эрх бүхий албан тушаалтан, дотоод мэдээлэл эзэмшигчийг;
 - 3.1.8 "Их хэмжээний хэлцэл" гэж Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасныг тус тус ойлгоно.

Дөрөв. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн илрэх хэлбэр

- 4.1 Сонирхлын зөрчилтэй хэлцэл нь дараах хэлбэрээр илэрч болно. Үүнд:
 - 4.1.1 Өөртэйгээ хийх хэлцэл: Гүйцэтгэх захирал, Эрх бүхий этгээдүүд нь хариуцсан ажлынхаа дагуу ямар нэг гэрээ, хэлэлцээр байгуулахад өөрөө оролцож, шийдвэр гаргаж ямар нэг байдлаар ашиг олох хэлцэл.
 - 4.1.2 Дотоод мэдээллийг ашиглаж арилжаанд орох замаар хийгдсэн хэлцэл: байгууллагын дотоод мэдээллийг өөртөө ашигтайгаар ашиглаж, ялангуяа нууцлалтай мэдээлэл болон дотоод мэдээллийн үндсэн дээр хийх хэлцэл.
 - 4.1.3 Бэлэг авсаны дагуу хэлцэл хийх хэлцэл: Эрх бүхий албан тушаалтан байгууллагатай ямар нэг бизнесийн харилцаанд орж байгаа гуравдагч этгээдээс бэлэг авч түүнд ашигтай хэлцэл байгуулах.
 - 4.1.4 Өөр байгууллагад давхар ажил эрхэлсэнээс үүсэх зөрчил: Хэрэв компанийн ажилтан, албан хаагч нь нэгээс илүү өөр компанид ажилладаг бол тухайн ажилтаны ажиллаж буй компанийн сонирхол нь хоорондоо зөрчилдөхгүй байх.
 - 4.1.5 Гэр бүлийн сонирхлоос үүсэх зөрчил: Гүйцэтгэх захирлын хүүхэд, эхнэр нөхөр болон бусад хамаатан саднаа ажилд авах явдал ба шударга бусаар буюу үндэслэлгүйгээр цалин нэмэх, албан тушаал ахиулах болон мөнгөн тусламж олгох зэргээр тухайн этгээдэд ашигтай байдлыг үүсгэх хэлцэл.

Тав. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавигдах шаардлага, хэлцэл хийх журам

- 5.1 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь ТУЗ-д дараах зүйлсийг хэлцэл хийхээс өмнө бичгээр мэдэгдэж, зөвшөөрөл авах үүрэгтэй:
 - 5.1.1 дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар;



- 5.1.2 өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг хуулийн этгээдийн болон тухайн этгээд оролцогч нь байдаг компанийн нэгдлийн бусад оролцогчийн талаар;
- 5.1.3 Компанийн хийхээр төлөвлөж байгаа байгаа хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухайгаа;
- 5.1.4 Компанийн тухай хуулийн 89.1-д заасан этгээд өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар.
- 5.2 Дараах тохиолдолд сонирхолын зөрчилтэй хэлцлийг хийж болно. Үүнд:
 - 5.2.1 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхолын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргана.
 - 5.2.2 Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах, эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу ТУЗ тогтооно.
 - 5.2.3 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн хэлцэл хийх талаар сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхийн саналаар гаргана.
 - 5.2.4 Сонирхолын зөрчилтэй хэлцлийг гагцхүү бичгээр хийнэ.
- 5.3 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцлох эрхгүй.
- 5.4 Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангана.
- 5.5 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн бол Компанийн үйл ажиллагааны тайландаа тусгаж нийтэд мэдээлнэ.

Зургаа. Сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдохгүй байх тохиолдлууд

- 6.1 Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.3 дахь хэсэгт зааснаас гадна дараах тохиолдлууд нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдохгүй буюу энэхүү журам үйлчлэхгүй болно. Үүнд:
 - 6.1.1 Бүх хувьцаа эзэмшигчид нь хэлцэлд сонирхол бүхий;
 - 6.1.2 Хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах эрхээ хэрэгжүүлэх;
 - 6.1.3 Хэлцэл байгуулсаны дараа нэгдмэл сонирхолтой этгээд болох;
 - 6.1.4 Компани хувьцаагаа эргүүлж худалдаж авах;
 - 6.1.5 Компанийн бүтээгдэхүүн үйлчилгээний батлагдсан стандарт нөхцөлийн дагуу байгуулах хэлцэл;

Долоо. Их хэмжээний хэлцэл

- 7.1 Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно. Үүнд:
 - 7.1.1 хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;
 - 7.1.2 компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.
- 7.2 Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг ТУЗ нь компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу тогтооно.
- 7.3 Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо ТУЗ нь аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшны уналтын түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.
- 7.4 Компани нэг өмчлөгчтэй бөгөөд уг этгээд гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх тохиолдолд энэ хуулийн арван нэгдүгээр бүлгийн заалт хамаарахгүй.

Хариуцлага

- 8.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Компанийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ, Компанид учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.
- 8.2 Сонирхлын зөрчил бүхий этгээд нь Компанид учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээж, гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

- 8.3 Компанийн энгийн хувьцаа эзэмшигч болон компанийн төлөөлөх эрх бүхий албан тушаалтан
Компанийн тухай хуулийн заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

---oOo---



Сонирхлын хэлцэл бүртгэх хуудас

*ХЭХ болон ТУЗ-ийн хурлын сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон тогтоол, шийдвэрийн эх хувийг энэхүү бүртгэлийн хавсралтаар хадгална.

№	Хэлцлийн мэдээлэл				Сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох хуулийн үндэслэл
	Хэлцлийн нөгөө тал	Хэлцлийн нэр	Огноо	Хэлцлийн дүн	
1					
2					
3					
4					

Хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол "Сонирхолын зөрчилтэй хэлцэл"-д тооцож бүртгэнэ.

1. Хэлцлийн нөгөө тал эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа
2. Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан
3. Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан
4. Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

Мэдээлэл өгсөн:/...../

Хүлээн авсан:...../...../

Мэдээлэл өгсөн огноо:

Нэгдмэл сонирхолтой этгээдийг бүртгэх хуудас

*Нэгдмэл сонирхолтой этгээд нь нэгдмэл сонирхолтой этгээдэд тооцогдох хамаарал нэмэгдсэн, өөрчлөгдсөн тохиолдолд тус баримтын талаар ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.

№	Нэр	Нэгдмэл сонирхолтойд хамаарал /Хуулийн үндэслэл/	Хувьцааны хамаарал		
			Төрөл	Тоо	Эзэмшил хувь
1					
2					
3					
4					

Компанитай дараах хамааралтай этгээдийг “Нэгдмэл сонирхолтой этгээд”-д тооцож бүртгэнэ.
Үүнд:

1. Тодорхой гэрээний үндсэн дээр хамтран тухайн компанийн удирдлагын шийдвэрийг тодорхойлох боломж бүхий бүлэг хүмүүс;
2. Группийн нэгдэлд хамаарч байгаа компанийн хувьд группийн нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан;
3. Группийн удирдагын шийдвэрийг хамтран тодорхойлох боломж бүхий компани болон хүн /бүлэг хүмүүс/
4. Нэг гэр бүлийн гишүүн, эцэг эх, хүүхэд, ач зээ, ах дүү, бусад төрөл садны хүн;
5. Нэг ХХК-н хувьцаа эзэмшигчид;

Мэдээлэл өгсөн:

Хүлээн авсан:.....

Мэдээлэл өгсөн огноо:

